

67

**МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМААС 2013 ОНЫ**  
**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧ**  
**НАЦАГИЙН УДВАЛЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**  
**“ТАВАН БОДЛОГО – ТАВАН ЗОРИЛТ”**

Монгол Улс өнө эртний төрт ёсны уламжлалтай, Их засаг хуулиа дэлхий дахинаа анх тунхаглаж, шударга ёсыг тогтоож байсан агуу түүхтэй гүрэн, монголчууд бид шударга байхдаа зоригтой, эвтэй байхдаа хүчтэй, байгаль дэлхий, уул усаа шүтэж амьдардаг агуу ард түмэн билээ.

Эцэг өвгөд минь уудам тэнүүн газар нутгийг минь Оюутолгой, Таван толгойн асар их баялагтай нь, Бороо, Төмөртэй, Асгат, Хөшөөтийг хар, цагаан, шар алттай нь, Мардай, Тамсагийг уран, нефтийн баялагтай нь бидэнд өвлүүлэн үлдээжээ.

Эцэг өвгөдийн минь үлдээсэн энэ их өвийг хаанахын хэн эзэмшиж байна вэ, хэн эндээс ашиг хүртэж байна вэ, газар нутаг, эрдэс баялагийнхаа жинхэнэ эзэд, ард түмэн бид ямаршуухан ахуй амьдралтай байна вэ гэсэн асуултыг нухацтай тавих цаг болжээ.

Улс орон ардчилсан нийгэмд шилжсэн, алдаа оноо нь ээлжилсэн сүүлийн 20 гаруй жилд төрийн эрхийг ээлжлэн болон хамтран барьж байсан эрх баригч Монгол Ардын нам, Ардчилсан намын улс төрийн алдаатай бодлогын хор уршгаар улс нийгэмд нэн даруй засаж сайжруулах ёстой 5 үндсэн аюул нүүрлээд байна. Үүнд:

**АЮУЛ 1:** Өвөг дээдсийн минь халуун амь, бүлээн цусаараа тэмцэж бидэнд үлдээсэн уул уурхайн асар их эрдэнэс баялагийг улс орон, ард түмнийхээ тусын тулд зөв зохистой ашиглахын оронд гадаадынханд найр тавин өгч үнэгүйдүүлж, хойч үеийнхээ ирээдүйг барьцаанд тавьсныг Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээ, Таван толгойн ордыг барьцаалан сонгуулийн авилгыг өөгшүүлсэн зэрэг үйл явдлууд гэрчилнэ. Эдгээр алдаанууд нь улс орны эдийн засгийн тусгаар тогтнолыг алдагдуулах аюулд хүргээд байна.

**АЮУЛ 2:** Иргэдийнхээ ахуй амьдралыг дээшлүүлэх чиглэлээр дорвитой ажил санаачилж хэрэгжүүлэхгүй, хамгийн үнэ цэнэтэй Монгол хүнийг ажилтай орлоготой болгохын оронд хавтгайруулсан халамжаар аргацааж ажилгүйдэл, ядуурлыг улс төрийн бодлогоор өөгшүүлж ирсэн нь Монгол хүнийг өөртөө итгэлгүй, сул дорой, үнэ цэнэгүй болгож, эх оронч үзлийг нь унтрааж, эр зоригийг мохоож, итгэл найдварыг алдагдуулж улмаар үндэсний дархлааг сулруулах аюулд хүргээд байна.

**АЮУЛ 3:** Ард иргэдийг нутаг ус, жалга дов, нам, эвсэл, хөдөө хот, хөрөнгө чинээгээр нь талцуулан хувааж, сонгуульд ялсан нам нь ялагдсан намынхаа гишүүдийг хоморголон ээлжлэн халж олныг хамарсан гомдол, бухимдлыг бий болгодог нь иргэдийг талцал хуваагдалд оруулж монголын нийгмийг бутарсан, задарсан, бухимдалтай, хувиа хичээсэн аминч шинжтэй болгосноор Үндэсний эв нэгдэлд аюул учраад байна.

**АЮУЛ 4.** Үндэсний аюулгүй байдал тэр дундаа эрүүл мэнд, экологийн аюулгүй байдал бүрэн алдагдлаа. Байгаль орчин бохирдож, монгол хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх ноцтой зөрчигдөж, онц аюултай, жигшмээр гэмт хэргүүд өдрөөс өдөрт нэмэгдэж, эрүүгийн нөхцөл байдал улам бүр хүндэрснээр Монгол хүн энх тунх байж, эсэн мэнд амьдрахад аюул учраад байна.

**АЮУЛ 5:** Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хууль дээдлэх, чөлөөт хэвлэл мэдээлэл, хараат бус шүүх, хүний эрх, эрх чөлөө зэрэг ардчилалын үнэт зүйлс алдагдаж, Үндэсний шударга ёсны тогтолцоо бүрэн хямралд орж, олон түмний шүүх ба төрд итгэх итгэл алдарч, нийгэм айдас хүйдэст автлаа. Сонгуулийн авилгаас эхтэй нийгэм, эдийн засгийн гүнзгий хямрал даамжирч улмаар хүний үндсэн эрхийг хангах, шударга ёсыг тогтооход бодитой аюул нүүрлэлээ.

Эдгээр аюулыг нэн даруй засахгүй бол Монгол Улсын маань хөгжил хэдэн арван жилээр ухарч, ард иргэдийн амьдрал улам доройтон, улмаар улс гэр маань орших уу, эс орших уу гэсэн салаа замын уулзварт тулж ирээд байна.

Энэ сонгууль бол зөвхөн хэн нэгэн хүнийг албан тушаал, эрх мэдэлд хүргэх төдий бус харин Монгол Улсын хөгжил дэвшил, газар нутгийн бүрэн бүтэн байдал, үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолоо хамгаалах, монгол хүнийхээ эрх, эрх чөлөө, хойч үеийнхээ баталгаат амьдралын төлөө сонголтоо хийх түүхэн сонгууль болно.

Иймд миний бие Монгол Улсын Тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, шударга ёсны төлөө тэмцэгч, эх орончдын нам болох МАХН-аас Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн хувьд Та бүхэн надад итгэл хүлээлгэж Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонговол дараах 5 бодлогыг тус бүрийнх нь 5 зорилтоор дамжуулан хэрэгжүүлэхээ амалж байна.

## “ТАБАН БОДЛОГО – ТАВАН ЗОРИЛТ”

### **БОДЛОГО 1. Бүрэн эрхт улсынхаа тусгаар тогтнолыг эдийн засгийн аргаар хамгаалж, бэхжүүлнэ.**

1.1. БНХАУ, ОХУ-тай түүхэн уламжлалт найрамдалт харилцаагаа эдийн засгийн харилцаагаар баяжуулж, гуравдахь хөршийн бодлогыг улам бүр өргөжүүлнэ. Түүхий эд нийлүүлэх урт хугацааны гэрээ хэлцлийг улс орнуудтай байгуулж, эдийн засгийн тогтвортой байдлыг хангана.

1.2. Далайд гарцгүй улсын хувьд экспортын бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлд хүргэх таатай нөхцлийг бий болгох талаар олон улсын хамтын нөхөрлөлийн байгууллагуудын дэмжлэгийг авахаар чармайж ажиллана.

1.3. Гадаадын хөрөнгө оруулалтыг харилцан ашигтай, шударга байх зарчмыг баримтлахын сацуу дотоодын хөрөнгө оруулагчиддаа давуу байдал олгодог болно.

1.4. Ашигт малтмал, газрын баялаг тэр дундаа Тавантолгой, Оюутолгой болон бусад стратегийн ордуудыг ард түмэндээ хамгийн ашигтай хувилбараар шийдвэрлүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.

1.5. Ази, европыг холбосон авто болон Төмөр замын сүлжээг бий болгож олон улсын торгоны замын уламжлалыг сэргээх талаар улс орнуудтай яриа хэлэлцээ хийж хэрэгжүүлнэ.

### **БОДЛОГО 2. Монгол төрийн бодлогын цөм нь “Монгол хүн” байна**

2.1. Хүүхэд залуучууд, эрэгтэй, эмэгтэйчүүд, ахмад настануудаа эрхэлсэн ажил, оршин суугаа газар, амьдралын орлогоос үл хамааран амьдралын баталгаа, аюулгүй байдлыг нь төрийн бодлогоор дэмжиж, хамгаална

2.2. Их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөр, программыг оновчтой болгон багасгаж, оюутнуудыг урин дулаан цагт бүтээн байгуулалтад оролцох, харин хүйтний улирал буюу 11 сараас 3 дугаар саруудад суралцах боломжийг гаргаж өгнө.

2.3. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүнд гэм буруутай этгээдийн өмчийн эрхийг нь шилжүүлэх, хүүхэд эмэгтэйчүүдийг хамгаалалтад авах замаар архидалт, гэр бүлийн хүчирхийлэлтэй шийдвэртэй тэмцэнэ.

2.4 Монгол хүний хөдөлмөрийн үнэлэмжийг бодитойгоор нэмэгдүүлэхийн тулд цалинг сараар биш цагаар тооцдог болгож, хөгжингүй орнуудын жишигт хүргэнэ.

2.5. Иргэддээ “Дарамтгүй бизнес” эрхлэх боломжийг төрийн зүгээс бүрдүүлж өгнө.

**ГУРАВ. Иргэддээ ижил тэгш хандаж, эхийн сэтгэлээр энэрэн халамжилж, Үндэсний аюулгүй байдлыг аргамжина**

3.1. Намчирхдаг, жалга довны үзлийг дэвэргэсэн өнөөгийн улс төр, сонгуулийн тогтолцоог үндэсний эв нэгдлийг бэхжүүлсэн улс төрийн тогтолцоо буюу сонгуулийн бүрэн пропорциональ (хувь тэнцүүлсэн) системд шилжүүлнэ.

3.2. Аймаг, хотын засаг дарга нарыг иргэд сонгож, харин сум, дүүрэг, баг хорооны засаг даргыг ажил, мэргэжлийн ур чадварыг нь харгалзан томилдог, хариуцлагаа хамтарч хүлээдэг зарчимд шилжүүлнэ.

3.3. Монгол Улсын үндэсний эрх ашгийн эсрэг, яс үндэс, үзэл бодол, намын харъяаллаар нь талцуулж, ашиг сонирхлын бүлэглэлүүдэд хуваах бодлогыг таслан зогсооно.

3.4. Улс төрийн намуудын ойлголцол, эв нэгдлийг хангаж төрийн тогтвортой байдлыг эрхэмлэн ажиллана. Аливаа улс төрийн асуудал, зөрчлийг харилцан буулт хийх, зөвшилцөх аргаар шийдвэрлэдэг улс төрийн соёлыг нэвтрүүлнэ.

3.5. Улс төр бизнесийн олигархи бүлэглэл үүсэх боломжийг бий болгосон тогтолцоог өөрчилж, татварын орчинг боловсронгуй болгох замаар цалин, тэтгэвэр, тэтгэмжийг бодитой нэмэгдүүлж, баян, ядуугийн ялгааг багасгахыг УИХ, Засгийн газраас шаардаж ажиллана.

**БОДЛОГО 4. Үндэсний аюулгүй байдлын “ХОТОЧ”-ийг ажиллуулна.**

4.1. Монгол хүний аюулгүй байдал ялангуяа эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах Үндэсний Аюулгүй байдлын “ХОТОЧ” –ийг бий болгоно.

4.2. Хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлж байгаа ундны усны хомсдол, цөлжилт, ус, хөрс, агаарын бохирдол, цөмийн болон бусад химийн аюултай хог хаягдал зэргийн хор хөнөөлийг нэн даруй арилгаж дахин шинээр үүсэн бий болохоос урьдчилан сэргийлнэ.

4.3. Архидалт хэмээх үндэсний эмгэнэл, гамшгийг монгол айл бүрийн амьдралын хэвшлээс арилгах төрийн бодлогыг дэмжинэ.

4.4. Зэвсэгт хүчин, хилийн цэрэг тус тусдаа, нэгдмэл зохион байгуулалтгүй байгааг өөрчилж, орчин үеийн хандлага, түүхэн уламжлалд нийцүүлэн батлан хамгаалах салбарыг бэхжүүлнэ.

4.5. Онц аюултай гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд оноох ялыг чангатгана. Хүний наймаа, эмэгтэйчүүд хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн хэрэгтэнд өршөөл, уучлал үзүүлэхгүй.

#### **БОДЛОГО 5. Шударга ёсны үндэсний тогтолцоог шинэчилнэ**

5.1. Монгол Улсад хууль хэрэгждэг болгоно. Улс төрийн, танил талын, эсхүл бусад шалтгаанаар шударга бусаар, хараат байдлаар хэрэг маргааныг шийдвэрлэсэн шүүгчидэд хариуцлага хүлээлгэж, шүүхийн авилгалыг устгана.

5.2. Улс төрийн сонгуулийн луйвар, сонгуулийн авилгалыг таслан зогсооно. Улс төрийн намын тухай хуулийг боловсронгуй болгож, сурталчилгааг нэгдсэн байдлаар төрөөс зохион байгуулдаг зохицуулалтыг санаачилж, бодлогоор дэмжинэ.

5.3. Монгол Улсад улс төрийн аливаа хэлмэгдүүлэлтийг таслан зогсоож, улс төрийн хоригдолгүй улс болгоно. Улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртсөн иргэдийг цагаатгуулна.

5.4. Хэвлэл, мэдээллийн салбарын байгууллагуудын бие даасан, хараат бус байдлыг хангаж, иргэдэд хүрч буй мэдээллийг шударга, үнэн зөв бодитой байлгах зорилгоор олон нийтийн хяналт, хариуцлагын тогтолцоог бий болгоно.

5.5. Авилга, хээл хахуулийн тухай эрх зүйн ойлголтыг боловсронгуй болгоно. Авилга авч өгөхгүй байх нөхцлийг бүрдүүлж төрийн албан тушаалтанд хууль бусаар нөлөөлдөг байдлыг хална.